**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Бугат сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код**: ГАА-2025/007/НА-СТА-ТШ3


Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086381
Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг:Sunjidmaae@audit.gov.mn


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт** /Баталгаажсан хувийг оруулах/

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.03.24 № 117

танай ______ -ны № ______ -т

БУГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Я.МЯТАВ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бугат сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Бугат сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 2,000.0 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 1,800.0 мянган төгрөгөөр, торгуулийн орлого 2,817.5 мянган төгрөгөөр, бууны албан татвар 950.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан,

8225020336

- Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 149,053.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд зохион байгуулсан сумын 100 жилийн ойн арга хэмжээний зардалд аймгийн төсвөөс санхүүжилт олгоогүй байна.

Засгийн газрын 2024 оны 231 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмсэн, мөн оны 83 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгожээ.

“Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор нийт 3 орон тоо нэмэгдсэн байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 444,500.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 574,163.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 118,728.9 мянган төгрөгөөр буюу 129.1 хувьтай биелүүлсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,053,613.6 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 157,546.1 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 138,846.1 мянган төгрөгийн, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 10,000.0 мянган төгрөгийн, Соёлын төвд 12,300.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус дутуу олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан, сумын ойн хандив болон бусад эх үүсвэрээс 1,228,142.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 8 хөтөлбөр 90 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 92.6 хувиар дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөг)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 938,293.7 | 939,082.2 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 637,029.6 | 602,011.9 |
| **33** | **АВЛАГА** | 121,872.6 | 86,883.1 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 0.0 | 0.0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 142,080.6 | 160,834.9 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 37,310.8 | 50,360.3 |
| **360** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | 0.0 | 38,992.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 1,277,418.4 | 1,640,543.0 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,277,418.4 | 1,640,543.0 |
| 39100 | Газар | 0.0 | 0.0 |
| **39200** | **Биет хөрөнгө** | 1,177,530.4 | 1,543,815.0 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 99,888.0 | 96,728.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 2,215,712.0 | 2,579,625.2 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 36,250.0 | 23,154.4 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 36,250.0 | 23,154.4 |
| **41300** | **Өглөг** | 36,250.0 | 23,154.4 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 2,179,462.0 | 2,556,470.8 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,179,462.0 | 2,556,470.8 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 604,481.9 | 604,481.9 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,352,165.2 | 1,729,174.0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 222,814.8 | 222,814.8 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 2,215,712.0 | 2,579,625.2 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөг)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,469,573.60 | 2,361,606.90 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 395,281.00 | 560,353.70 |
| **110** | Орлогын албан татвар | 295,973.40 | 526,858.40 |
| **1100** | Хувь хүний орлогын албан татвар | 312,731.60 | 546,923.70 |
| **1101** | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (16,758.20) | (20,065.30) |
| **113** | Хөрөнгийн албан татвар | 33,588.80 | 17,119.50 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 65,718.80 | 16,375.80 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 323,864.30 | 555,452.20 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 323,864.30 | 555,452.20 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 1,750,428.40 | 1,245,801.00 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 2,180,334.00 | 1,730,584.90 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,180,334.00 | 1,730,584.90 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,089,975.60 | 1,688,464.30 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 446,838.20 | 752,223.40 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 76,704.10 | 91,353.00 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 152,715.80 | 506,330.90 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 41,338.80 | 45,851.90 |
| **2105** | Нормативд зардал | 300.00 | - |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,637.00 | 7,024.20 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 6,254.00 | 6,515.00 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 176,332.10 | 14,083.60 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 187,855.60 | 265,082.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,090,358.40 | 42,120.60 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 289,239.60 | 631,022.00 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 79,530.10 | 254,013.20 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | 209,709.50 | 377,008.80 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** (мянган төгрөг)

| **Код:** | **Тайлангийн үзүүлэлт** | **2023оны 12-р сарын 31** | **2024 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,266,448.30 | 1,860,403.70 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 395,281.00 | 560,353.70 |
| **110** | Орлогын албан татвар | 295,973.40 | 526,858.40 |
| **1100** | Хувь хүний орлогын албан татвар | 312,731.60 | 546,923.70 |
| **1101** | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (16,758.20) | (20,065.30) |
| **113** | Хөрөнгийн албан татвар | 33,588.80 | 17,119.50 |
| **118** | Бусад татвар, төлбөр, хураамж | 65,718.80 | 16,375.80 |
| **1180** | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 4,947.60 | 5,468.00 |
| **1181** | Газрын төлбөр | 12,237.20 | 10,730.40 |
| **1182** | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 48,534.00 | 177.30 |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 81,790.80 | 54,249.00 |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 81,790.80 | 54,249.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 1,789,376.50 | 1,245,801.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,974,774.80 | 1,567,548.20 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,974,774.80 | 1,567,548.20 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 861,416.40 | 1,526,927.70 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 447,102.00 | 743,444.00 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 76,704.10 | 91,353.00 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,527.60 | 506,330.90 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 34,679.70 | 47,038.50 |
| **2105** | Норматив зардал | 300.00 | - |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,202.00 | 8,138.90 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 6,254.00 | 6,515.00 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 210,440.60 | 60,888.70 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 67,206.50 | 63,218.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,113,358.40 | 40,620.60 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 291,673.50 | 292,855.50 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 340,078.00 | 327,873.20 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 340,078.00 | 327,873.20 |
| **2200** | Дотоод эх үүсвэрээр | 340,078.00 | 327,873.20 |
| **2260** | Гадаад эх үүсвэрээр | - | - |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | (340,078.00) | (327,873.20) |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | (15,000.00) | - |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 15,000.00 | - |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | (63,404.50) | (35,017.70) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 700,434.10 | 637,029.60 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 637,029.60 | 602,011.90 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** (мянган төгрөг)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Төөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 0.0 | 1,969,752.5 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 0.0 | 1,969,752.5 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | 0.0 | 209,709.5 |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 0.0 | 2,179,462.0 |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 0.0 | 2,179,462.0 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 0.0 | 2,179,462.0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 377,008.8 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 0.0 | 2,556,470.8 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** (мянган төгрөг)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,305,853.50 | 1,850,222.98 | 455,630.52 | 80.2 |

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,737,300.90 | 1,554,253.79 | 183,047.11 | 89.5 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,695,978.90 | 1,513,633.23 | 182,345.67 | 89.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 858,765.20 | 743,444.03 | 115,321.17 | 86.6 |
| 210101 | Үндсэн цалин | 470,587.00 | 415,533.16 | 55,053.84 | 88.3 |
| 210102 | Нэмэгдэл | 301,135.00 | 261,778.22 | 39,356.78 | 86.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,456.00 | 15,799.00 | 2,657.00 | 85.6 |
| 210104 | Урамшуулал | 68,587.20 | 50,333.66 | 18,253.54 | 73.4 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 107,624.70 | 91,353.04 | 16,271.66 | 84.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 77,640.70 | 64,771.78 | 12,868.92 | 83.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,496.00 | 7,046.23 | 449.77 | 94.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,996.80 | 4,025.50 | 1,971.30 | 67.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,499.20 | 1,778.00 | -278.80 | 118.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,992.00 | 13,731.54 | 1,260.46 | 91.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 524,472.40 | 506,330.87 | 18,141.53 | 96.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 31,405.40 | 26,267.10 | 5,138.30 | 83.6 |
| 210302 | Түлш, халаалт | 492,217.00 | 480,063.77 | 12,153.23 | 97.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 850 | - | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,808.60 | 40,905.80 | 1,902.80 | 95.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,600.00 | 2,301.65 | 1,298.35 | 63.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,480.00 | 33,471.75 | 8.25 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,320.00 | 955.9 | 364.10 | 72.4 |
| 210404 | Ном, хэвлэл | 208.6 | - | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,200.00 | 1,198.50 | 1.50 | 99.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,000.00 | 2,978.00 | 22.00 | 99.3 |
| **2105** | **Нормативд зардал** | 1,200.00 | - | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,200.00 | - | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,000.00 | 17,562.90 | 3,437.10 | 83.6 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,000.00 | 9,798.70 | 3,201.30 | 75.4 |
| 210604 | Урсгал засвар | 8,000.00 | 7,764.20 | 235.80 | 97.1 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,344.00 | 6,515.00 | 829.00 | 88.7 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | - | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,344.00 | 6,515.00 | 829.00 | 88.7 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 68,190.00 | 52,307.98 | 15,882.02 | 76.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 63,000.00 | 51,043.88 | 11,956.12 | 81.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200 | 65.34 | 134.66 | 32.7 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 400 | 35.17 | 364.83 | 8.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 150 | 1.8 | 148.20 | 1.2 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,440.00 | 440 | 3,000.00 | 12.8 |
| 210807 | Газрын төлбөр | 1,000.00 | 721.79 | 278.21 | 72.2 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 64,574.00 | 55,213.60 | 9,360.40 | 85.5 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 61,054.00 | 52,321.50 | 8,732.50 | 85.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,520.00 | 2,892.10 | 627.90 | 82.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 41,322.00 | 40,620.56 | 701.44 | 98.3 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 41,322.00 | 40,620.56 | 701.44 | 98.3 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 39,222.00 | 38,521.56 | 700.44 | 98.2 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,100.00 | 2,099.00 | 1.00 | 100.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 488,552.60 | 295,969.19 | 192,583.41 | 60.6 |
| 223001 | Бусад хөрөнгө | 488,552.60 | 295,969.19 | 192,583.41 | 60.6 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 80,000.00 | - | | |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 80,000.00 | - | | |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,305,853.50 | 1,892,610.81 | 413,242.69 | 82.1 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,987,433.50 | 1,842,313.28 | 145,120.22 | 92.7 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,677,300.90 | 1,545,826.51 | 131,474.39 | 92.2 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 310,132.60 | 296,486.77 | 13,645.83 | 95.6 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 318,420.00 | 50,297.53 | 268,122.47 | 15.8 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 75,000.00 | 48,462.10 | 26,537.90 | 64.6 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,835.43 | | |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 243,420.00 | - | | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 287,835.71 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 330,223.53 | | |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан** (мянган төгрөг)

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **76,246.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **76,246.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **45,198.45** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,632.70** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,632.70 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,580.75** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,580.75 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **29,985.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,985.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,048.28** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **31,048.28** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 31,048.28 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **76,246.73** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **76,246.73** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 68,265.73 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,981.00 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

**3.1** Аудитаар нийт 599.5 сая төгрөгийн 1 алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан байна.
**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- ЗДТГ нь орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгийг Өмч төрийн/ ТӨҮГ/ гэсэн зардлын ангилал дээр 599.5 мянган төгрөгийг тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй зөрчлийн дүн 164.7 сая төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 25.9 сая төгрөгөөс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 164.7 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлсэн.

**3.1.1 Харьяа байгууллагууд**
Бугат сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол болон урсгал зардал нэгтгэсэн байна.

Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж "Хязгаарлалттай"дүгнэлт өгсөн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол болон урсгал зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

**3.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар санхүүгийн тайланг 440.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 3 алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 96.5 сая төгрөгийн 4 зөрчилд зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.
**3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар санхүүгийн тайланг 51.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 1 алдааг залруулж, 43.6 сая төгрөгийн 6 зөрчилд зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 7.8 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна.

**3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 164.7 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлж зөрчилд зөрчил арилгах, давтан гаргахгүй 3 албан шаардлага хүргүүлсэн байна.

**3.3 Албан шаардлага**

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 2.0 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 1.8 сая төгрөг, торгуулийн орлого 2.8 сая төгрөг, бууны албан татвар 0.9 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх",Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн 78 дугаар тогтоол" гэж заасантай нийцэхгүй , эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр хангаж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 640.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 491.5 сая төгрөгийн алдааг залруулсан ба 149.0 сая төгрөгийн төгрөгийн 11 зөрчил илэрч 0.9 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 140.2 сая төгрөгийн 9 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага, 7.8 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; 16.5.6-т "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

**5.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Орон нутгийн төсвөөс 157.1 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн. Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 138.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 10.0 сая төгрөг, Соёлын төвд 12.3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Эрдэнэ Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагуудад санхүүжилтийг олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэзэс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бугат сумын Засаг дарга | 1 | 599,593.6 | - | - | 1 | 599,593.6 | 1 | 599,593.6 | - | - | | - |
| Бугат сумын Засаг даргын Тамгын газар | 1 | 51,082.3 | - | - | 1 | 51,082.3 | 1 | 51,082.3 | | | | - |
| Бугат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | 695.0 | - | - | 1 | 695.0 | 1 | 695.0 | - | - | | - |
| Бугат сумын Хоршоо хөгжүүлэх сан | 1 | 589.6 | - | - | 1 | 589.6 | 1 | 589.6 | - | - | - | - |
| Бугат сумын Орон нутгийн хөгжлийн сан | 1 | 439,163.1 | - | - | 1 | 439,163.1 | 1 | 439,163.1 | - | - | | |
| Бугат сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| **Дүн** | **5** | **1,091,123.6** | **-** | **-** | **5** | **1,091,123.6** | **5** | **1,091,123.6** | **-** | **-** | | |

**4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Бүгд | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзах | Түүвэрт | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бугат сумын Засаг дарга | 1 | - | 1 | - | - | - | 3 | 164,714.2 | - | - | 3 | 164,714.2 | - | - |
| Бугат сумын Засаг даргын Тамгын газар | 1 | | 1 | - | - | - | 6 | 51,562.74 | - | - | 5 | 43,694.4 | 1 | 7,868.3 |
| Бугат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | - | - | - | - | 1 | 1 | 665.0 | - | - | 1 | 665.0 | - | - |
| Бугат сумын Хоршоо хөгжүүлэх сан | 1 | - | - | - | - | 1 | 2 | 8,213.3 | 1 | 935.0 | 1 | 7,278.3 | - | - |
| Бугат сумын Орон нутгийн хөгжлийн сан | 1 | - | - | - | - | 1 | 2 | 88,612.3 | - | - | 2 | 88,612.3 | - | - |
| Бугат сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан | 1 | - | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **6** | | **2** | **-** | **-** | **4** | **14** | **313,767.54** | **1** | **935.0** | **12** | **304,964.2** | **1** | **7,868.3** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР